

## НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР 2016 ОНЫ ЁС ЗҮЙН ХОРООНЫ ТАЙЛАН

1. *Төлөвлөгөө*: НМХГ-ын Ёс зүйн хороо нь ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажлын төлөвлөгөөг 2016 оны Ёс зүйн хорооны 1 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн батлав.

2. *Сургалт*: Албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд сургалт зохион байгуулсан. Үүнд:

2.1. 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр Байгаль орчин геологи, уул уурхайн хяналтын хэлтсийн нийт улсын /ахлах/ байцаагчдад сургалт зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо 24.

2.2. НМХГ-ын улсын /ахлах/ байцаагчдаас гаргасан акт, албан шаардлага, дүгнэлт, Захиргаа, хууль эрх зүй, хүний нөөцийн хэлтсээс хүний нөөцийн асуудлаар гаргасан тушаалуудын эрх зүйн үндэслэлийг хянаж, дүгнэлт гаргасан. Маргаан бүхий эрх зүйн зохицуулалтын талаар эрх зүйчдийн дунд “Удирдлагын шийдвэрийн эрх зүйн үндэслэл” сэдвээр сургалт, хэлэлцүүлэгийг 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан эрх зүйн мэргэжилтнүүдийн тоо 14. Эрх зүйчдэд Төрийн албан хаагчийн ёс зүй сэдвээр сургалт орж, сургалтын хөтөлбөр, лекцийг эрх зүйчдэд өгсөнөөр эрх зүйчид тус бүрийн дүүргүүд дэх МХХ-ийн улсын байцаагчдад ёс зүйн хичээл орсон.

2.3. 2016оны 07 дугаар сарын 01-ны өдөр 09 цагт Хан-Уул дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн нийт албан хаагч, улсын байцаагчдад “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүй” сэдвээр сургалт зохион байгуулав. Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо 27.

2.4. 2016 оны 10 дугаар сарын 14-ний өдөр шинээр томилогдсон албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр сургалт хийв. Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо 20.

Жич: Сургалтын хөтөлбөрийг цаг үеийн нөхцөл байдалд тохируулан байнга сайжрууж, онолын болон практик мэдлэгийг хөтөлбөрт оруулан, ёс зүйн зөрчлийн жишээ бодлого оруулж байна.

3. *Сурталчилгаа, мэдээлэл*: Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын цахим хуудас <http://ub.inspection.gov.mn/index.php/en/>-ын Хууль эрх зүйн буланд Ёс зүйн дүрэм, журам, ёс зүйн хорооны үйл ажиллагааны талаар тогтмол мэдээллэж байна.

3.1. НМХГ-ын Авлигын эсрэг 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг Ёс зүйн хороотой холбоотой асуудлаар тайлан гаргаж өгөв. Ёс зүйн хорооны Авлигын эсрэг төлөвлөгөөний жилийн биелэлт 100 хувь.

3.2. Төв орон нутгийн мэргэжлийн хяналтын болон хуулиар эрх олгогдсон байгууллагуудад ажиллаж байгаа улсын байцаагчдын зүгээс дотоод, гадаадын аж ахуйн нэгж байгууллагуудад зүй бусаар хяналт шалгалт хийж хүнд суртал, дарамт шахалт, чирэгдэл учруулсан ёс зүйн зөрчил гаргасан асуудлаарх судалгааг гарган МХЕГ-т хүргүүлэв.

4. *Ёс зүйн зөрчлийн талаар*: Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар мэдээллийн дэлгэрэнгүйг харах/ Тайлант хугацаанд 2016 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 11 дүгээр сарын 16-ны өдрийн хооронд ёс зүйн зөрчлийн талаар өргөдөл,

гомдол 19ш ирсэн. Улсын байцаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол 16ш, улсын байцаагч албаны үнэмлэх, тэмдэгээ үрэгдүүлсэн тухай өргөдөл 3ш ирсэн байна. Ёс зүйн хороонд ирсэн өргөдөл гомдлыг судлан шалгаж, ёс зүйн зөрчилтэй асуудлаар маргаан үүсгэж, нийт 6 удаагийн хуралдааныг зарлан хуралдуулсан. Өргөдөл гомдлыг 100% шийдвэрлэсэн.

5. *Архив, албан хэрэг хөтлөлт*: Ёс зүйн хорооны 2015 оны хийсэн ажлын тайлан, хурлын тэмдэглэл, дүгнэлт, өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдал 1 боть архивын нэгж хүлээлгэн өгөв.

---000---